

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН “САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ” 2017 ОНЫ
01 ТООТ АЛБАН ДААЛГАВРЫГ ЦАГААНДЭЛГЭР СУМАНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2018.12.04

№	Албан даалгавраар өгсөн үүрэг	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Хувь
0	1	2	3	4
1	Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах	1.УИХ, Засгийн газар, ИТХ, Засаг даргын тогтоол шийдвэр, захирамж, албан даалгаврыг цаг алдалгүй иргэд, малчдад хүргэн хэрэгжүүлж ажиллах 2. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарын ил тод байдал хэсэгт байршуулан сурталчлах 3. Ёс зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцон ажиллах 4. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө тусган албан хаагчдийг дотоодын сургалтанд хамруулж мэргэшүүлэх	1. Монгол Улсын Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 16 заалт бүхий сумын төлөвлөгөө батлан, албан байгууллагуудад хүргүүлж, байгууллагууд тусгай төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг тооцож ажиллалаа. Авлигатай тэнцэх газраас 2017 онд МУЗГ-т хүргүүлсэн зөвлөмж, оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалттай сумын төрийн байгууллагуудын албан хаагчдад танилцуулж мэдээлэл хүргэж нийт 83 албан хаагчаар гарын үсэг зуруулан баталгаажуулан авсан. Мөн ЗГ-ын 2018 оны 32, 258-р тогтоолуудыг ЗДТГ-ын албан хаагчид болон байгууллагын дарга нарт танилцуулж хэвлэн өгч гарын үсэг зуруулан баталгаажуулж байгууллынхаа албан хаагчдад танилцуулж мөрдөж ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн. УИХ болон ЗГ, аймгийн Засаг дарга, зэрэг дээд шатны байгууллагаас ирүүлсэн тогтоол шийдвэр, захирамжийг тухай бүр хүлээн авч албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мэдээлж, хөдөөгийн иргэдэд багийн даргаар дамжуулан биеэр болон утсаар цаг алдалгүй шуурхай хүргэж цахим хуудсаар тогтмол мэдээлж мэдээллийн самбаруудаар ил тод байрлуулж хэвшсэн. 2. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмын сумын төрийн байгууллагуудын цахим хуудас болох “Цагаандэлгэрийн мэдээ” болон байгууллага тус бүрт тараан	100

		өгч мэдээллийн самбартаа байршуулан сурталчилж ажиллалаа. 3. Байгууллага тус бүр дээр ёс зүйн баг байгуулагдан төлөвлөгөө гарган ажилласан. Ажилтан, албан хаагч тус бүртэй ёс зүй хариуцлагын гэрээ байгуулан хэрэгжилтийг тооцож ажиллалаа. Ажилдаа хариуцлагагүй хандсан 4 албан хаагч, ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчийг холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулсан. 4. Байгууллага тус бүр “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан баталж, жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж ажилласан. Цэцэрлэгээс эрхлэгч УБ хотод 2 удаа, аймаг бүсийн сургалтанд 9 удаа, багш нар 4 удаа аймгийн төвд сургалтанд хамрагдсан. Ажлын байрны дотоод сургалтыг 6 удаа явуулж багш ажилчид 100% хамрагдсан. СӨБ-ийн багшийн ангид эчнээгээр туслах багш Б.Өлзийжаргал, сантехникийн мэргэжил олгох сургалтанд жижүүр Э.Дорждавгыг хамруулж мэргэжлийн үнэмлэхтэй болгож суралцах хугацааны цалинг 50-иар олгож дэмжиж ажиллалаа. ЕБС, СӨБ-ийн багш нар боловсролын чиглэлээр зохион байгуулсан бүх төрлийн сургалт семинарт 100% хамрагдсан. ЭМТ-ийн эмч, албан хаагчид болон ЗДТГ-ын албан хаагчид аймаг, орон нутгаас зохион явуулсан улс аймаг, бүсийн орон нутгийн дотоодын сургалтуудад хөтөлбөр, удирдамжийн дагуу хамрагдсан. Тухайлбал ЗДТГ-аас 1 мэргэжилтнийг ХААИС-д эчнээгээр, ЭМТ-өөс 1 сувилагчийг вакциinator сувилагчийн 3 сарын курст, 1 сувилагчийг Дорноговь аймаг дахь АШУИС-д лаборантаар, дүн бүртгэгчийг Улаанбаатар хотод архив, бичиг хэргийн 1 сарын сургалтанд соёлын төвөөс 1 ажилтныг СУИС-ийн соёлын сургуульд номын санчийн эчнээ ангид 1 ажилтныг нийгмийн ажилтнаар суралцуулж мэргэшүүлэх тал дээр төрийн албан хаагчдыг дэмжин ажиллаж байна. Улаанбаатар хотод 3 удаагийн, аймгийн төвд болсон 15 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 28 албан хаагч хамрагдсан байна.	100 100 100
--	--	---	----------------------------------

2	Авилгын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авилга, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх	5.Удирдах албан тушаалтныг урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлж хянуулж ажиллах	5. Энэ онд Засаг даргын орлогч, 1, 2-р багийн Засаг дарга нийт 3 улс төрийн албан хаагч шинээр томилогдсон. АТГ-ын дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэст материалыг хүргүүлэн ашиг сонирхлын зөрчилгүй тухай албан тоот ирсний дараа томилсон.	100
		6.Шинээр гарсан хууль тогтоомж, журам, бодлогын баримт бичгээр сургалт зохион байгуулах	6. 2019 оны 1 сарын 1-ээс хэрэгжих Төрийн албаны тухай хуулийн сургалтанд 78 төрийн албан хаагч, ЗГ-ын 2018 оны 32, 258-р тогтоолыг танилцуулах сургалтанд 26, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаарх сургалтыг төрийн албан хаагчдад хийж нийт давхардсан тоогоор 131 иргэн, төрийн албан хаагчийг хамруулсан.	100
		7.Захиргааны шийдвэр гаргах, гэрээ хэлэлцээр байгуулах, хэлэлцэх оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбарыг гаргаж ажиллах	7. Төрийн албан хаагчдад захиргааны шийдвэр гаргах, аливаа асуудал хэлэлцэж шийдвэрлэхийн өмнө ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбарыг гаргаж ажиллах талаар мэдээлэл хийсэн. 5 мэдэгдэл тайлбар гарсан.	70
3	Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагын өндөржүүлэх: Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв"-д иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах	8. Иргэдээс санал, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах санал хүсэлтийн хайрцгийг тогтмол ажиллуулж, иргэдээс ирүүлсэн, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч бүртгэх, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэж өгөхөд анхаарах	8. Засаг даргын Тамгын газрын СӨГомдол хүлээн авах утас 89643553, ЭМТ-д 89826055 нээлттэй утаснуудыг ажиллуулж байна. Албан байгууллага, албан хаагч нарт 2018 онд иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдол, ирсэнийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд хяналтын картаар хяналт тавьж, улирал бүрийн эцэст СӨГ-ийн мэдээг нэгтгэн тайланг холбогдох байгууллагад цахимаар болон цаасаар хугацаанд нь хүргүүлж ажилласан. 2018 оны 11 сарын эцсийн байдлаар нийт 335 санал хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, иргэдэд хариуг цаасаар болон утсаар, биеэр уулзаж хариуг өгч ажиллалаа.	100
4	Төрийн албаны үр ашгийг сайжруулах:	9.Төрийн албан хаагчдийн ажлын байрны тодорхойлолтыг дахин	9. ЗДТГ нь албан хаагчдынхаа ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах ажлын хэсгийг тушаалаар	

	Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих	боловсруулах ажлын хэсгийг томилон дүн шинжилгээ хийж ажил үүргийн хуваарь, ачааллыг оновчтой болгох 10. Цаг ашиглалтыг сайжруулж хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгч хариуцлагажуулах	батлан ажиллуулж ажил үүргийн хуваарь, ачааллыг тэнцвэржүүлэх талаар саналаа хэлэлцэн ажлыг байрны тодорхойлолтод тусган шинэчлэн баталсан. Цэцэрлэгээс ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийж дахин боловсруулах ажлын хэсгийг эрхлэгчийн 16 тоот тушаалаар томилон ажиллуулаа. Ажлын хэсэг нь албан хаагчдад хуучин ажлын байрны тодорхойлолтыг 7 хоног судлах чиглэл өгч, багш ажилчидад ажлын байрны тодорхойлолт гэж юу вэ, хэрхэн хэрэгжүүлж, ажиллах талаар сургалтыг 09 сарын 19-нд зохион байгуулан 11 ажилтан оролцлоо. 09 дүгээр сарын 20-ны өдөр ажлын байрны тодорхойлолтын талаар хэлэлцүүлэг, дүгнэлт гаргаж харилцан ярилцаж шинээр оруулах саналуудыг тусган ажлын байрны тодорхойлолтыг шинээр зааврын дагуу боловсруулан, ажилтан нэг бүрт танилцуулан гарын үсэг зуруулж, ажлын хэсгийн ахлагч гарын үсэг зурж, эрхлэгчээр баталгаажууллаа. ЭМТ нь 2018 онд 18 ажилчдын ажлын байрны тодорхойлолтонд анализ, дүгнэлт хийж шинэчилсэн. Орлон гүйцэтгэх ажлыг илүү сайн тусгаж оруулсан. Албан хаагчдын хувийн хэргийн шинэчлэн бүрдүүлж ажиллаж байна. Соёлын төвөөс 2018 оны 01 сары 24-ны өдөр ЗГ-ын 34 дугаар тогтоолын дагуу Соёлын төвийн 4 албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж ажил үүргийн чиг үүргийг нарийвчлан тогтоож, ажлын ачааллыг тэнцвэржүүлсэн. Томилогдсон ажлын хэсэг нь Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль зэргийг бусад албан хаагчдад танилцуулж ажиллалаа. ЕБС-аас ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийж ажлын давхардал хийдлийг тэнцвэржүүлэхэд анхаарч захиралын тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилж 22 албан хаагчийн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж албан хаагчдад танилцуулж баталгаажуулсан. 10. Ажил амралтын цагийг хөдөлмөрийн хуульд зааснаар үндэслэл болгон баримталж ажилладаг. Мөн аймгийн Засаг	100
--	---	--	--	-----

			даргын захирамжийн дагуу 5 сарын 1-ээс 10 сарын 1 хүртэл ажлын цаг 08-17, 10 сарын 1-ээс 5 сарын 1 хүртэл ажлын цаг 09-18 цаг гэж тогтоосныг мөрдлөг болгон ажиллаж байна. Байгууллагын дотоод хяналт, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, ажлыг үр дүнтэй, бүтээмжтэй, сахилга хариуцлагатай болгох зорилгоор ЗДТГ болон ЭМТ-д хурууны хээ уншигч, камер ажиллаж байна. Бүх байгууллагууд даваа гариг бүр шуурхай хурлаа хийж бүх ажилчдыг үүрэг даалгаврын дэвтэржүүлж ажлыг 7 хоногоор төлөвлүүлэн хэрэгжилийг мөн 7 хоногоор тайлагнуулж биелэлтэнд байгууллагын удирдагууд хяналт тавин ажилласнаар ажлын бүтээмж дээшлэх үр дүн гарч байна. ЕБС, цэцэрлэг, соёлын төв 12 сард байгууллагадаа хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмж 1050000 төгрөгөөр авч суурилуулж албан хаагчдын цагийг бүртгэн ажиллаж байна.	100
5	Бодлогын тогтвортой хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвортой суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	11. Томилгооны зөрчилгүй ажиллах 12. Хүний нөөцийн судалгаа гаргаж хэрэгцээ шаардлагатай боловсон хүчнийг мэргэшүүлэх 13. ТАХ-ийг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч нийгмийн баталгааг хангах, сургалт семинарт хамруулж мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай, бүтээлч санаачлагатай ажиллаж байгаа ТАХ-ийг урамшуулах	11. Энэ онд Засаг даргын орлогч, 1, 2-р багийн Засаг дарга нийт 3 улс төрийн албан хаагч шинээр томилогдсон. АТГ-ын дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэст материалыг хүргүүлэн ашиг сонирхлын зөрчилгүй тухай албан тоот ирсний дараа томилсон. Мөн төрийн захиргааны 3 орон тооны захиалгыг аймгийн ТАСЗ-д хүргүүлсэн. 12. Дутагдалтай боловсон хүчний судалгааг гаргасан. Сургуульд дуу хөгжмийн багш, соёлын төвд хөгжмийн багш, ЭМТ-д сувилагч 1, ЗДТГ-т 3 орон тоо дутагдалтай байна. 2018 онд цэцэрлэг СӨБ-ийн багш, тогооч, ЕБС-д 3 багш, ЭМТ-д 1 их эмч дутагдалтай байсныг нөхөж байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Үүнээс ЭМТ-ийн 2 сувилагч, соёлын төвд 1 ажилтан, ЗДТГ-аас жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн зэрэг хүмүүсийг мэргэшүүлэх сургалт болон эчнээ ангиудад суралцуулсан байна. 13. Төрийн албыг тасралтгүй явуулах зарчмыг баримтлан байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллахад сургалт семинарт тогтмол хамруулж мэргэших, мэргэжил эзэмшихэд	100 100

	чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх	16. Төрийн ажил үйлчилгээ болон албан хаагчдийн талаар санал асуулга явуулж, хариуцлага тооцож ажиллах	ирүүлж нийт саналын 44%-ийг НӨАТ-ын баримт өгөхгүй байгаа талаар илэрхийлснийг холбогдох газруудад мэдэгдэж ажилласнаар Хөрс ШТС, ЭЭС, Сайн гашуун ХХК, Сирина ХХК НӨАТ-ын баримт олгоод байна. Соёлын төв нь улирал бүр ард иргэдээс үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, мөн цаашид хийх шинэлэг ажлын саналыг авч ажилладаг. 2018 оны 03-р сарын 30-нд 1-р улирлын санал асуулгыг 42 иргэнээс, 09 сарын 19-нд 3-р улирлын санал асуулгыг нийт 22 иргэнээс авч цаашид анхаарах болон хийх ажлыг сар бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Албан хаагчдаас ажлын байрны нөхцөл байдлын талаар сэтгэл ханамжийн судалгааг нийт 3 удаа авсан. Судалгаанаас үндэслэн номын сан, орон нутаг судлах танхим 2-ыг тусгаарлан тохижуулж ажиллах таатай нөхцлийг бүрдүүлсэн. ЭМТ саналт, хүсэлт, өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах хайрцаг, журнал нээж, нээлттэй утас 89826055 байрлуулан ажиллуулаад байна. 2018 оны 4 сард ЗДТГ-тай хамтран “Нээлттэй” хаалганы өдөрлөг хийж, сэтгэл ханамжийн судалгааг 64 хүнээс авсан. Гарсан санал 4 байна. Үүнд: 1.ЭМТ-ийн тусламж үйлчилгээтэй холбоотой 2.Хүүхдийн өрөөг тохижуулах 3.ЭЭС-ийн даатгалаар олгогддог эмийн нэр төрлийг сайжруулах 4. Сувилагч нарыг чадавхжуулах зэрэг саналууд гарсныг шийдвэрлэж ажилласан байна.	
Хэрэгжилтийн хувь				96,2%

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР